



СЕКЮРИТИЗ
ҮЦК

Үнэт цаас гаргах

Гарын авлага



Яагаад үнэт цаас гаргадаг вэ ?

» Компаниуд яагаад үнэт цаас гаргадаг вэ?


- Компанийн үйл ажиллагаа өргөжих
- Компанийн ирээдүйн хөгжилд хувь нэмэр оруулах стратегийн хөрөнгө оруулагчтай болох
- Компанийн нэр хүнд харилцагч, хэрэглэгч, нийлүүлэгч, хөрөнгө оруулагчдын хүрээнд өсөх мөн олон нийтэд танигдах
- Компанийн засаглалын сайн тогтолцоо бүрдэх
- Чадварлаг боловсон хүчин, сайн менежментийн баг бүрдүүлэх
- Зээлийн дарамтгүй үйл ажиллагаа явуулах
- Ирээдүйд нэмэлт хөрөнгө татах үйл явцыг хялбаршуулах
- Хүссэн үед үнэт цаасаа арилжаалах
- Хямд өртөгтэй хөрөнгийн эх үүсвэрийг татах хамгийн боломжит хувилбар

» Үнэт цаас гаргахын өмнө харгалзах асуудлууд

- Компанийн үнэ цэнэд зах зээлийн нөхцөл байдал нөлөөлөх
- Удирдлагын эрх хуваагдах
- Мэдээллийн ил тод байдал



Компани үйл ажиллагаандаа шаардлагатай хямд өртөг бүхий урт болон богино хугацаатай санхүүгийн эх үүсвэрийг хэрэгцээ шаардлагадаа тулгуурлан үнэт цаас гаргадаг



Үнэт цаасаа
амжилттай гаргах
нь хөрөнгө
оруулалт татах
зөвхөн эхний
алхам бөгөөд таны
бизнесийг шинэ
түвшинд хөгжүүлэх
ЭХЛЭЛТИЙН ЦЭГ

Үнэт цаас гаргах үйл явц

» Үнэт цаас гаргах бэлтгэл ажил

Үнэт цаас гаргахаар төлөвлөж буй байгууллагууд юуны өмнө дотоод бэлтгэл ажлыг хангасан байх нь үнэт цаас гаргах үйл ажиллагааг үр дүнтэй, түргэн шуурхай явуулах гол хүчин зүйл болох төдийгүй зах зээлийн таатай үеийг алдалгүй ашиглах давуу талыг өөртөө бий болгодог.

Үнэт цаас гаргах үйл явцад ихээхэн цаг хугацаа зарцуулагдах хэдий ч энэ нь компани өөрийн компанийн засаглал, санхүү болон үйл ажиллагаандаа үнэлэлт дүгнэлт хийн сул талуудыг илрүүлэх, түүнийг засах боломжийг бий болгодог.

» Хэрхэн амжилттай үнэт цаас гаргах вэ ?

- Зорилго, зорилтоо хоёрыг эрт тодорхойлох
- Компаниа чадавхижуулж, сайн түүхийг бүтээх
- Давуу талаа нэмэгдүүлж, сул талаа багасгах
- Эдийн засгийн хүнд нөхцөлд үргэлж бэлтгэлтэй байх
- Хөрөнгө оруулалт татах боломжуудыг судлах
- Үнэт цаас гаргах дотоод бэлтгэл ажлуудыг хангах


Үнэт цаасны зах зээлийн боломж



Макро орчин

| | Бодит ДНБ / Өсөлт / | Бодлогын хүү | Инфляц |
|---------|------------------------|--------------|--------|
| 2016 Q3 | -1.4% | 15% | -0.1% |
| 2017 Q3 | 5.8% | 12% | 5.8% |
| 2018 Q3 | 6.4% | 10% | 5.7% |


2016 Q3- 2018 Q3



Эх сурвалж: Монгол банк

Үнэт цаасны зах зээл


Зах зээлийн үнэлгээ (тэр.төг)



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

- » 2018 оны байдлаар “Монголын хөрөнгийн бирж” ХК болон “Монголын үнэт цаасны бирж” ХК-ийн хувьцааны зах зээлийн үнэлгээний нийлбэр дүн 2,508.04 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 71.72 тэрбум төгрөг буюу 2.94 хувиар өссөн үзүүлэлт юм.


Хөрвөх чадварын үзүүлэлт (хувь)



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

- » ЗЗҮ-нд хувьцааны арилжааны үнийн дүнг харьцуулж тооцсон зах зээлийн идэвхийг харуулах хөрвөх чадварын үзүүлэлт нь 2018 оны жилийн эцсийн байдлаар 9.7 хувь байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.5 пунктээр өссөн үзүүлэлт юм.

Үнэт цаасны зах зээлийн индекс




Эх сурвалж: Монгол Банк

- » МХБ-ийн “Үнэт цаасны үнийн индекс тооцоолох журам”-ын дагуу бүртгэлтэй компаниудыг зах зээлийн үнэлгээ, арилжааны өдрийн дундаж гүйлгээ, арилжаанд орсон өдрийн тоо, төвлөрлийн байдал зэрэг үзүүлэлтүүдээр үнэлж, ТОП-20 индексийн багцыг бүрдүүлэх ба багцыг жил бүр шинэчилдэг.
- » Тайлант хугацаанд ТОП-20 индексийн дээд үзүүлэлт 24520.35 нэгж, доод үзүүлэлт 10485.74 нэгж, дундаж үзүүлэлт 14594.9 нэгж байна.

Үнэт цаасны зах зээлийн оролцогчид

Хороонд бүртгэлтэй хувьцаат компани,
өмчийн хэлбэрээр



■ Төрийн өмчит


■ Төрийн өмчит оролцоотой

■ Хувийн өмчит

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

- » 2018 оны хагас жилийн байдлаар Хороонд бүртгэлтэй хувьцаат компаниудыг өмчийн хэлбэрээр нь авч үзвэл, 253 хувьцаат компани буюу 83 хувь нь хувийн өмчийн хэлбэртэй байна.

Хувьцаат компанийн тоо



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

- » 2018 оны хагас жилийн байдлаар 300 хувьцаат компани Хороонд бүртгэлтэй байна. Энэ онд шинээр IPO гаргасан таван компани дотоодын хөрөнгийн зах зээлээс нийт 27 гаруй тэрбум төгрөгийг татан төвлөрүүлжээ. Энэ нь хувьцааны анхдагч зах зээлийн арилжаа нийт хувьцаа арилжааны 11.06 хувийг бүрдүүлсэн үзүүлэлт юм.

Үнэт цаас гаргах үйл явц

» Үнэт цаас гаргахад оролцогч талууд

- Зөвлөгөө өгөх
- Компанийн болон үнэт цаасны танилцуулгыг бэлтгэх
- Үнэт цаасыг анхдагч зах зээлд худалдан борлуулах
- Танилцуулах аян

- Хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх
- Компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх эсэх
- Хуулийн дүгнэлт

- Ня-бо бүртгэлийн бодлого улсын стандартад нийцэж байгаа эсэх
- Танилцуулгад тусгагдсан санхүүгийн мэдээлэл нь бодит байдалд нийцэж байгаа эсэх

- Андеррайтер шаардлагатай гэж үзсэн тохиолдолд мэргэжлийн шинжээчийг томилоно

- Компанийн үнэлгээ, бизнесийн үнэлгээг “Олон улсын үнэлгээний стандарт”, “Хөрөнгийн үнэлгээний тухай хууль”-н дагуу гаргана



Хөрөнгө оруулагчдын эрэлтийг нэмэгдүүлэх

» **Компанийн тогтвортой байдлыг нэмэгдүүлэх**

- Шинэлэг шинэ төслүүдийг хэрэгжүүлэх боломжтой байх
- Компанийн ирээдүйн өсөлт, хөгжил тодорхой байх
- Компанийн засаглалыг сайжруулах, мэдлэг туршлагатай баг, ажилтантай байх
- Эрсдэл даах чадвартай байх
- Өрсөлдөх чадвартай байх

» **Андеррайтерийн компаниа оновчтой сонгох**

- Чадварлаг зөвлөхүүдийг сонгох
- Зах зээлд өрсөлдөхүйц үйлчилгээний хөлстэй
- Хөрөнгө оруулагчдын бааз суурь, харилцаа холбоо сайтай
- Үнэт цаас гаргасны дараах хөрөнгийн зах зээл дээрхи үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх боломжтой

Хөрөнгө оруулагчдын эрэлтийг нэмэгдүүлэх

» Маркетингийн оновчтой үйл ажиллагааг

- Маркетингийн оновчтой төлөвлөгөө боловсруулах
- Үнэт цаас гаргах тухай нийтэд мэдээлэхээс өмнө маш цөөн тооны зорилтот хөрөнгө оруулагчидтай эхний уулзалтуудыг амжилттай хийх
- Мэдээллийн зохимжтой сувгуудаар дамжуулан хөрөнгө оруулагчдыг мэдээллээр хангах

» Зорилтот хөрөнгө оруулагчдыг сонгох

- Мэргэжлийн хөрөнгө оруулагчид
- Стратегийн, урт хугацааны хөрөнгө оруулагч хайж олох
- Ирээдүйд хамтран ажиллаж болох хувь хүн, мэргэжлийн байгууллага олох
- Жижиг хөрөнгө оруулагч

» Зах зээлээ сайн мэдрэх

- Макро төвшинд нарийн шинжилгээ хийж, ирээдүйн таамаглалаа тодорхойлох
- Үнэт цаасны арилжааг зохион байгуулж, захиалгын санг бүрдүүлснээр эрэлтэд үндэслэсэн үнэт цаасны үнийг тогтоох

Үнэт цаас гаргах шалгуур үзүүлэлт (бүртгэлийн шалгуур)




Монголын хөрөнгийн биржид бүртгүүлэхийн тулд үнэт цаас гаргагч нь “Үнэт цаасны бүртгэлийн журам”-аар тогтоосон үйл ажиллагаа явуулсан жилийн, борлуулалтын орлогын, ажлын капиталын, хувьцаа эзэмшигчдийн тооны шалгуур, шаардлагыг хангасан байх шаардлагатай байдаг.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

| Шалгуур/ Ангилал | I ангилал | II ангилал | III ангилал |
|---|---|--|---|
| Үйл ажиллагаа явуулсан жил | Тухайн чиглэлээр 3-аас доошгүй | Тухайн чиглэлээр 2-оос доошгүй | - |
| Санхүүгийн тайлан | 3 жил СТОУС /IFRS/ | 2 жил СТОУС /IFRS/ | 2 жил СТОУС /IFRS/ |
| Сүүлийн жилийн борлуулалтын орлогын хэмжээ | 5.0 тэрбумаас дээш | - | - |
| Сүүлийн жилийн ашгийн хэмжээ | 1 тэрбумаас дээш | 100 саяас доошгүй байх | - |
| Ажлын капитал | - | Бүртгэгдсэнээс хойш 12 сарын хугацаанд хангалттай байх | - |
| Компанийн засаглалын зарчмыг дагаж мөрдөх | + | + /мөрддөггүй бол тайлбарлах/ | + /мөрддөггүй бол тайлбарлах/ |
| Удирдлагын багийн туршлага, түүний болон хяналтын багц эзэмшигчид | Сүүлийн 2 жилийн дотор компанийн гүйцэтгэх удирдлагын багийн бүрэлдэхүүний 2/3-т, сүүлийн 1 жилд хяналтын багц эзэмшигчдийн бүтцэд томоохон өөрчлөлт ороогүй байх. | - | - |
| Зах зээлийн үнэлгээ | 10.0 тэрбумаас дээш | 1.0 тэрбумаас дээш | Компанийн саналыг харгалзан биржээс тухай бүр тогтоосон шаардлагыг хангах |
| Олон нийтэд эзэмшүүлэх хувь | 25%-иас доошгүй эсвэл арилжааны 5% дээш | 25%-иас доошгүй | - |
| Хувьцаа эзэмшигчдийн тоо | 100-аас доошгүй | 50-аас доошгүй | - |
| Үнэт цаас нь арилжигдах боломжтой байх | Бүртгүүлэх үнэт цаас нь барьцаалагдах зэргээр гуравдагч этгээдийн эрхээр үүрэгжээгүй, битүүмжлэгдээгүй, өмчлөх эрхийг шилжүүлэхэд аливаа хязгаарлалтгүй, чөлөөтэй шилжих, арилжигдах боломжтой байх | | |

Бүртгэлийн алхам үе, шат



Бүртгэлийн хураамж

Бүртгэлийн хураамж (сая төгрөг)

| Шалгуур/ Ангилал | | I ангилал | II ангилал | III ангилал |
|---------------------------------------|--|--|------------|-------------|
| Өргөдлийг хүлээн авч хянах хөлс | Шинээр болон нэмж үнэт цаас бүртгүүлэх | 2 | | |
| | Бүртгэлд өөрчлөлт оруулах | 1.5 | | |
| | Бүртгэлээс хасах | 1.5 | | |
| Үнэт цаасыг бүртгэх үйлчилгээний хөлс | Хувьцаа | 50-500 | 25-250 | 5-50 |
| | Засгийн газрын бонд | Татан төвлөрүүлэх хөрөнгийн 0.025% | | |
| | Компанийн бонд | Татан төвлөрүүлэх хөрөнгийн 0.1% /2.5 саяас доошгүй байна/ | | |
| | Гадаад улсын үнэт цаас гаргагч | Биржээр арилжаалсан хувьцааны үнийн дүнгийн 1% | | |
| Жилийн үйлчилгээний хөлс | | 1.2-50 | 1.2-50 | 0.5-25 |

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Бонд болон IPO

» Бондын санхүүжилт

- **Хаалттай бонд:** Аль ч хэлбэрийн компани хаалттай бондыг гаргаж болох ба тодорхой тооны хөрөнгө оруулагчдад санал болгон арилжаална. Хаалттай бонд нь эргэн төлөгдөх нөхцөлтэй эсхүл компанийн үнэт цаасанд хөрвөх нөхцөлтэй байж болно.
- **Нээлттэй бонд:** Олон нийтэд санал болгон арилжаалдаг. Мөн хөрөнгө оруулагчид нээлттэй бондыг худалдан авсныхаа дараа бирж хоорондоо арилжаалах боломжтой.



Бонд нь банкны зээлтэй төстэйгээр тодорхой хугацаатай, тодорхой хэмжээний хүүтэйгээр, тодорхой хэмжээний мөнгөний өр тавьж байгааг гэрчилсэн бичиг юм

» Бондын онцлог

- Санхүүжилтийн хугацаа
- Санхүүжилтийн хэмжээ
- Хүүгийн хэмжээ



Компанийн мөнгөн хөрөнгийн эргэлтийн мөчлөгт тааруулан хүүгийн төлбөрийг төлөх хугацаа болон үндсэн төлбөрийг эргүүлэн төлөх хугацааг компани өөрийн хүсэлд тааруулан тодорхойлох



Нийтэд санал болгон гаргах бондын үнийн дүн нь тухайн компанийн өөрийн хөрөнгийн хэмжээнээс илүүгүй байх бөгөөд шаардлагатай санхүүжилтийн хэмжээгээр хүссэнээрээ гаргах



Зах зээлийн хүүнээс хамаарч, хадгаламжийн болон зээлийн хүүгийн дундажруу тэмүүлсэн, хөрөнгө оруулагч болон компанид ашигтай байхаар хүүгийн хэмжээг компани өөрөө тодорхойлох

Бонд болон IPO

» IPO

- IPO нь англиар **Initial Public Offering** гэсэн үгсийн товчлол Монгол хэлнээ “анх удаа хувьцаагаа нийтэд санал болгох” гэсэн үг
- Цөөн тооны хөрөнгө оруулагчидтай байсан компани өөрийн хувьцааг **олон нийтэд нээлттэй** санал болгох үйл ажиллагаа
- Эрх зүйн талаас нь авч үзвэл, хязгаарлагдмал хариуцлагатай компани (ХХК) хэлбэрээ өөрчилж, **хувьцаат компани** (ХК) болж байгаа хэрэг

Бонд болон хувьцааны ялгаа

| Хувьцаа | Бонд |
|--|---|
| Эргэн төлөгдөх нөхцөлгүй хөрөнгө оруулалт | Тодорхой хугацааны дараа эргэн төлөгдөнө |
| Өмчлөгчийн хувьд өөрт ноогдох ноогдол ашиг авна | Зээлийн эзний хувьд зээлийн хүүг авна |
| Хувьцааны ноогдол ашиг компанийн ашигт ажиллагаанаас хамаарах тул тогтмол биш байж болно | Компанийн ашиг алдагдлаас үл хамааран анх тогтсон хүүг тогтмол авна |
| Хөрвөх чадвар сайтай. Хоёрдогч зах зээл дээр арилжаалагддаг, өөрөөр хэлбэл хувьцаа эзэшигчид хоорондоо арилжиж болдог. | Хөрвөх чадвар хувьцаанаас сул. Гэхдээ хүссэн үедээ хоёрдогч зах зээл дээр арилжиж болно. |
| Компани оршин тогтнох бүх л хугацаанд хүчин төгөлдөр. Зээлийн хугацаанд хүчин төгөлдөр. | Зээлийн хугацаанд хүчин төгөлдөр. |
| Компани дампуурвал хувьцаа эзэмшигчид өөрт ноогдох хөрөнгийг компанийн бүх өр төлбөр, зээлийг барагдуулж дууссаны дараа авдаг. | Компани дампуурвал зээл олгогчид өөрийн зээлдүүлсэн хөрөнгийг хүүгийн хамт хамгийн түрүүнд авдаг. |
| Ашиг өндөр -> Эрсдэл өндөр | Ашиг бага -> Эрсдэл бага |



Холбоо барих:

Ард Секюритиз ҮЦК

Утас: +(976) 11 – 321899, +(976) 96025445

И-мэйл: info@ardsecurities.com

Веб хаяг: <http://ardsecurities.com>

“Ард Холдингс”-ын байр 2 дугаар давхар,
Ерөнхий сайд Амарын гудамж, Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар хот, Монгол улс

